

ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
СТАТИСТИК, ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ БАЯРААГИЙН БАЯСГАЛАНГИЙН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин	Эхэлсэн дууссан хугацаа	Биелэлт ийн хувь
1	2	3	4	5	6	7	8
1.	Гадаад худалдааны статистик мэдээллийг түгээх, боловсронгуй болгох	-Гадаад худалдааны статистик мэдээллийг хүлээн авсан хэрэглэгчийн тоо болон цахим лавлагаа авсан хэрэглэгчийн нийт тоо, гадаад худалдааны статистикийн ухаалаг хайлтын програмыг сайжруулсан модулийн тоо	Гаалийн цахим үйлчилгээний систем https://gaali.mn/ -ээс "Барааны экспорт, импортын статистикийн мэдээлэл"-ийг 2023 оны 11 дүгээр сарын 30-ны байдлаар 481 аж ахуй нэгж, иргэн авсан хандалт хийсэн бол 2024 оны 11 дүгээр сарын 30-ны байдлаар 1867 аж ахуй нэгж, иргэн авсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1386 хэрэглэгчээр буюу 4 дахин өссөн үзүүлэлттэй байна. /Эх сурвалж: Gaali.mn Статистик цонхон дахь хандалтын тоогоор/ Мөн Гаалийн цахим үйлчилгээний систем https://gaali.mn/ -ээс; Гаалийн мэдүүлгээр бүрдүүлэлт хийсэн барааны лавлагаа; авахаар 2023 оны 11 дүгээр сарын 30-ны байдлаар 19934 аж ахуй нэгж, иргэн хандсан бол 2024 оны 11 дүгээр сарын 30-ны байдлаар 39754 аж ахуй нэгж, иргэн авсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 99%-аар өссөн үзүүлэлттэй байна.	-Гадаад худалдааны статистик мэдээллийг хүлээн авсан хэрэглэгч /хандалт/, цахим лавлагаа авсан хэрэглэгчийн тоо өмнөх оны мөн үеэс өссөн байна. -Гадаад худалдааны статистикийн ухаалаг хайлтын программыг сайжруулсан байна.	<u>Нэг.Гадаад худалдааны статистик мэдээлэл гаргах ажлын хүрээнд:</u> Үндэсний Статистикийн Хороо, Гаалийн ерөнхий газрын дарга нарын 2015 оны А/14, А/15 хамтарсан тушаалаар батлагдсан "Барааны экспорт, импортыг бүртгэх, статистикийн үзүүлэлтийг тооцох аргачлал"-ыг үндэслэн гадаад худалдааны 2024 оны урьдчилсан болон жилийн эцсийн гүйцэтгэл, 2025 оны 1, 2, 3, 4, 5 дугаар сарын барааны статистик мэдээлэл, динамик статистик мэдээллийг боловсруулж гаалийн цахим хуудас www.gaali.mn/statistics сайтад байршуулсан. 1.Барааны экспорт, импортын статистикийн мэдээлэл гаргахдаа дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн.Үүнд: 1-р хавсралтын дүнг бусад бүх хавсралтын дүнтэй тулган шалгах бүх хавсралтуудыг хянах 8-р хавсралтыг өмнөх сартай харьцуулж хянах 8-р хавсралтыг дундаж үнээр хянах 4-р болон 5-р хавсралтыг дундаж үнээр хянах	2025.01.01-2025.06.10	100

					• Товч танилцуулга бичих 2.Барааны экспорт, импортын статистикийн дэлгэрэнгүй танилцуулгыг хийхэд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд: • Танилцуулгад ашиглагдах хүснэгтүүдийг 2022, 2023, 2024 оны мөн үеэр бэлдэх /6 төрлийн хүснэгт/ • График байгуулах /Тоон мэдээлэлдээ үндэслэн танилцуулга бичих, нийт 12 хуудас/ 3. Гадаад худалдааны нийт бараа эргэлт, экспорт, импортын гол нэрийн барааны тоо хэмжээ, зарим барааны экспорт, импортын мэдээллийг өссөн дүнгээр нийт 6 удаа гаргаж сар бүрийн эхэнд инфографик хэлбэрээр ГЕГ-ын Олон нийтийн харилцах албаар дамжуулан дотоод сүлжээ болон гаалийн цахим хуудсанд нийтлэн ажиллалаа. <u>Хоёр. Захиргааны статистик мэдээллийг гаргах ажлын хүрээнд</u> 1. ГЕГ-ын даргын 2023 оны 12-р сарын 20-ны өдрийн А/676 тушаалаар шинэчлэгдэж 24 хавсралтаар тухайн журамд заасан аргачлалын дагуу сар бүрийн 15-ны дотор гаргадаг. Энэ ажлын хүрээнд сар бүр журамд заасны дагуу нийт 13 хавсралтыг ГЕГ-ын газар хэлтсүүдээс авч бусад 8 хавсралтыг тус хэлтсийн статистикч ГУБ Tableau болон CAIS-аас мэдээлэл бодуулж боловсруулалтын хийж ажилладаг. Дээрх мэдээнүүдийг нэгтгэн боловсруулж, 24 хавсралтаар тайлбар танилцуулгын хамтаар гаргаж 2024 оны бүтэн жилийн (дараа оны 1-р сард гардаг) болон 2025 оны 1, 2, 3, 4-р сарын захиргааны статистикийн мэдээллийг cerp.ecustoms.mn-ын “Захиргааны статистик” талбарт байршуулсан. Шаардлагатай тохиолдолд ГЕГ-ын дарга болон ГЕГ-ын дэд даргад хэвлэмэл байдлаар хүргүүлэн ажилладаг.		
--	--	--	--	--	---	--	--

					2.Тайлант хугацаанд 2024 оны бүтэн жилийн (дараа оны 1-р сард гардаг) болон 2025 оны 1, 2, 3, 4-р сарын захиргааны статистикийн мэдээлэлд сүүлийн 3 жилийг харьцуулсан байдлаар дүн шинжилгээг сар бүр хийж /сар бүр 15 хуудас/ cerp.ecustoms.mn-ын “Захиргааны статистик” талбарт байршуулсан. 3.Үндэсний Статистикийн хороонд сар бүр “Захиргааны статистик мэдээлэл” -ийн 6, 7, 8, 14а, 14б маягтуудыг хүргүүлэн ажиллаж байна. 4.“Захиргааны статистик мэдээлэл”-ийг зөвхөн гаалийн байгууллагын хэмжээнд ашигладаг бөгөөд cerp.ecustoms.mn-д байршуулдаг. Тайлант хугацаанд давхардсан тоогоор нийт 667 хэрэглэгч буюу cerp.ecustoms.mn-д бүртгэлтэй гаалийн байгууллагын албан хаагч нар уншиж танилцан дотоод хэрэгцээндээ ашигласан байна. Өмнөх оны мөн үеэс 21.3 хувиар өссөн байна. 5. Мөн CERP системд өмнөх 2016-2020 онуудын Захиргааны статистикийг мэдээллийг байршуулсан. <u>Гурав.Гадаад худалдааны статистик мэдээлэл хүлээн авсан хэрэглэгч хандалт:</u> Гаалийн цахим үйлчилгээний систем https://gaali.mn/ -ны Статистик цонхонд Гадаад худалдааны барааны статистик мэдээллийг сар бүр байршуулан ажиллаж байна. 1.Гаалийн цахим үйлчилгээний систем https://gaali.mn/ : 2024 оны 6 дугаар сарын 31-ний байдлаар 649 аж ахуй нэгж, иргэн экспорт, импортын статистик мэдээллийг авсан хандалт хийсэн бол 2025 оны 6 дугаар сарын 12-ны байдлаар 3,180 аж ахуй нэгж, иргэн авсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад		
--	--	--	--	--	---	--	--

				2531 хэрэглэгчээр 4 дахин буюу 390 хувиар өссөн үзүүлэлттэй байна. 2. Гаалийн цахим үйлчилгээний системээр https://gaali.mn/: 2024 оны 6 дугаар сарын 10-ны байдлаар 6801 /ААН-4245, иргэн 2556/ аж ахуй нэгж, иргэн гаалийн мэдүүлгээр бүрдүүлэлт хийсэн лавлагаа авсан бол 2025 оны 6 дугаар сарын 10-ны байдлаар 23420 /ААН-5768, иргэн 17652/ аж ахуй нэгж, иргэн авсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 244%-аар өссөн үзүүлэлттэй байна. /Эх сурвалж: “Астелишн” ХХК/ 3. Мөн хэлтсийн 11-353568 утсаар холбогдсон иргэн, аж ахуй нэгжид Гаалийн цахим үйлчилгээний систем https://gaali.mn/-ээс гаалийн мэдүүлгээр бүрдүүлэлт хийсэн лавлагаа, гадаад худалдааны барааны статистик мэдээлэл хэрхэн авах талаар хэлтсийн бичиг хэрэг хариуцсан ГУБ нар тухай бүр зааварчилгаа өгч ажилласан. <u>Дөрөв. Үндэсний Статистикийн Хороотой хамтарч ажилласан байдал:</u> Сангийн сайдын 2025 оны 18-р тушаалаар батлагдсан “Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлтийг хангуулах чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ”-ний дагуу гаалийн байгууллагын авч хэрэгжүүлэх төлөвлөгөөний 5.4-т заасны дагуу Үндэсний статистикийн хороо, Гаалийн ерөнхий газрын даргын хамтарсан 2015 оны А/14, А/15 тушаалын батлагдсан “Барааны экспорт, импортыг бүртгэх, статистикийн үзүүлэлтийг тооцох аргачлал”-ын дагуу мэдээллийг боловсруулан гаргаж, хянаж ажилласан. 2025 оны 3-р сарын 21-нд ҮСХ-той холбогдох газрын дарга н.Оюунжаргал, хэлтсийн дарга н.Энхбаатар, хэлтсийн ахлах н.Ихэртөр бусад нэгжийн түвшинд ГЕГ-ын СДШХ-ийн дарга, статистикч ГУБ-ын хамтаар уулзалт хийж мэдээлэл солилцох гэрээг		
--	--	--	--	--	--	--

					шинэчлэх, гадаад худалдааны статистикийн мэдээллийг эдийн засгийн ангиллын дагуу гаргах судалгааг хамтран хийхээр тохиролцсоны дагуу мэдээлэл солилцох гэрээний шинэчилсэн төслийг Хуулийн хэлтэст 2025.04.28-ны өдрийн №01600/217 дотоод хянуулан төслийг 2025.05.16-ны өдөр ҮСХ-ний ахлах мэргэжилтэн н.Ихэртөрд цахим файлаар хүргүүлсэн. , мөн гадаад худалдааны статистикийн мэдээллийг эдийн засгийн ангиллаар гаргахын тул гадаад худалдаа эрхлэгч ААН-ын бүртгэлийг Үндэсний Статистикийн хороонд хүргүүлсний үр дүнд нийт 27273 ш ААН-ын бүртгэлийг салбар, дэд салбараар ангилуулж ажилласан болно. Тус эдийн засгийн ангиллыг салбараар ялгасан ААН-ын жагсаалтыг ГЕГ-ын Мэдээллийн технологийн газарт 2025.06.06-ны өдрийн 01600/323 дугаар дотоод албан бичгээр хүргүүлж ажилласан. Хүрсэн түвшин: -Гадаад худалдааны статистик мэдээллийг хүлээн авсан хэрэглэгчийн /хандалт/ өмнөх оны мөн үеэс 412 хувиар, цахим лавлагаа авсан хэрэглэгчийн тоо өмнөх оны мөн үеэс 244 хувиар өссөн. -Гадаад худалдааны статистикийн ухаалаг хайлтын програмыг 3 чиглэлээр сайжруулнаар үр дүн гарсан.		
2.	Гадаад орны гаалийн байгууллагын хамтын ажиллагааны хүрээнд гадаад худалдааны мэдээлэл солилцох үйл	Хэрэгжилтийн эерэг үзүүлэлт	2023 оны БНХАУ болон ОХУ-тай хийх зэрэгцүүлэлтийн мэдээллийг боловсруулан ГХАХ-р дамжуулан БНХАУ, ОХУ-аас мэдээллээ ирүүлэх талаар албан хүсэлт тавьсаны үндсэн дээр ОХУ-аас 2023 оны мэдээллийг ирүүлсэн. Харин БНХАУ-ын талаас 2023 оны гадаад худалдааны	Худалдааны түнш орнуудтай гадаад худалдааны мэдээллийг цахим хэлбэрээр солилцсон байна.	1. ОХУ, БНХАУ-д гадаад худалдааны 2024 оны жилийн эцсийн мэдээлэл гарсантай холбоотойгоор зэрэгцүүлэлт хийх мэдээллийг Гадаад хамтын ажиллагааны хэлтэст цахим сүлжээгээр 2025.04.22-ны өдөр СДШХ-ийн 01600/200, 01600/201 дугаар дотоод зурвасаар дамжуулан хүргүүлэх ажлыг зохион байгуулсан. 2. ГХАХ-ны хэлтсээр дамжуулан БНХАУ, ОХУ-аас мэдээллээ ирүүлэх талаар албан хүсэлт	2025.01.01-2025.06.10	100

	ажиллагааг хөгжүүлэх	статистикийн зэрэгцүүлэлтийг хийх боломжгүй гэж ГЕГ-ын ГХАХ-ээр дамжуулан мэдэгдсэн. Монгол улс, ОХУ хооронд 2023 онд хийсэн гадаад худалдааны барааг БТКУС-ийн орон тус бүрээр зөрүүг гаргах, их зөрүүтэй барааг тогтоох, зөрүүг нарийвчлан шалгах, учир шалтгааныг тогтоох зэрэгцүүлэлтийн ажлыг 2024 оны 9 дүгээр сарын 10-аас хийж эхэлсэн. Зэрэгцүүлэлт хийх барааг сонгон БТКУС-ийн 4 орны түвшингээр /экспортын 6 бараа, импортын 9 бараа /гарган ОХУ-ын Холбооны гаалийн албанд хүргүүлсэн. ОХУ-ын талаас экспортын 4, импортын 3 барааны жагсаалт ирүүлсэн. Монгол улс, ОХУ-ын хооронд 2023 онд хийсэн гадаад худалдааны статистикийн зэрэгцүүлэлт хийх экспертүүдийн 4 дүгээр уулзалт 2024.10.03-аас 2024.10.04-ний өдрүүдэд Улаанбаатар хотод зохион байгуулагдсан бөгөөд 2 талын санал солилцсон экспортын 10, импортын 12 барааны зэрэгцүүлэлтийг хийж, зөрүү үүссэн шалтгааныг нарийвчлан тогтоосон. Зэрэгцүүлэлтийн уулзалтыг протокол үйлдэн баталгаажуулан ГХАХ-т хадгалуулсан. Монгол улс, ОХУ хооронд хийсэн гадаад худалдааны 2023 оны статистикийн зэрэгцүүлэлт хийсэн тайланг ГЕГ-ын Мэргэжлийн зөвлөлийн хуралд танилцуулсан.	тавьсны үндсэн дээр БНХАУ-аас 2025.03.25-ны өдөр файлаар, ОХУ-ын ЭСЯ-аас 2024 оны мэдээллийг 2025.05.27 дискээр ирүүлсэн. /Эдгээр мэдээлэл нь урьдчилсан байдлаар тул зэрэгцүүлэлт хийх боломжгүй./ Хүрсэн түвшин: Худалдааны түнш орнуудтай гадаад худалдааны мэдээллийг цахим хэлбэрээр солилцсон.		
--	----------------------	--	---	--	--

3.	Цахим технологийг ашиглан статистикийн мэдээлэл түгээх, их өгөгдлийг боловсруулсан байдал	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	1. Нийт 1046 алдааг илрүүлсэн. 2. Төрийн байгууллага, ААН, иргэдэд 133 албан бичгийн хариуг хүргүүлсэн. 3. ЗББНДБ-уудад 681 дотоод зурвасаар хариу өгсөн. 4. www.gaali.mn -ээс гадаад худалдааны статистик мэдээллийг 1867 аж ахуй нэгж, иргэн авсан. 5. www.gaali.mn -ээс 39754 аж ахуй нэгж, иргэн лавлагаа авсан байна. 6. "Статистик, дүн шинжилгээний програм"-д нийт 3 шинэ модуль хөгжүүлэлт хийсэн.	1.Цахим технологийг ашиглан статистикийн мэдээлэл түгээсэн байна. 2.Гадаад худалдааны статистик мэдээллийг хүлээн авсан хэрэглэгч /хандалт/, цахим лавлагаа авсан хэрэглэгчийн тоо өмнөх оны мөн үеэс 5 хувиар өссөн байна. 3. Гаалийн мэдүүлгийн статистик, дүн шинжилгээний шинэ модулийг "Статистик, дүн шинжилгээний програм"-д бодлогын даалгавар боловсруулж, хөгжүүлж, нэвтрүүлсэн байна.	1. Гаалийн автоматжуулсан удирдлагын систем CAIS http://cais.ecustoms.mn/ болон ТАБЛБЮ https://cuss.ecustoms.mn/ програм ашиглан гаалийн мэдүүлгээр үүсгэсэн мэдүүлгийн цахим сангаас гадаад худалдааны барааны статистикийн мэдээлэл, захиргааны статистикийн мэдээлэл, төрийн болон төрийн бус байгууллага, аж, ахуй нэгж, иргэдэд мэдээ мэдээлэл, лавлагааг гарган ажиллаж байна. 2. 2025 оны эхний харас жилийн байдлаар https://edoc.ecustoms.mn/ албан бичгийн програмаар төрийн байгууллагаас 124, аж ахуй нэгж иргэнээс 42, харьяа гаалийн газар хороодоос 55 албан бичиг ирсний дагуу 104 албан бичгийн хариуг хүргүүлсэн. 3. ЗББНДБ-уудаас ирүүлсэн 379 дотоод зурвасын дагуу мэдээ мэдээллийг гаргаж, санал хүргүүлэхээр 362 дотоод зурвасаар хариу өгсөн. 4. Мэдээ мэдээлэл, лавлагаагаар үйлчилсний төлбөрт нийт 2,855,000 төгрөгийг Төрийн сан банкны 100900011003 тоот дансанд тушаалгасан. 5. Гаалийн цахим үйлчилгээний систем www.gaali.mn -ны Статистик цонхонд Гадаад худалдааны барааны статистик мэдээллийг сар бүр байршуулж ажилласанаар 2024 оны 6 дугаар сарын 31-ний байдлаар 649 аж ахуй нэгж, иргэн экспорт, импортын статистик мэдээллийг авсан хандалт хийсэн бол 2025 оны 6 дугаар сарын 12-ны байдлаар 3,180 аж ахуй нэгж, иргэн, , CERP системд 147 авсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2531 хэрэглэгчээр 4 дахин буюу 412 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Гаалийн цахим үйлчилгээний системээр https://gaali.mn/: 2. Гаалийн цахим үйлчилгээний системээр https://gaali.mn/: 2024 оны 6 дугаар сарын 10-ны байдлаар 6801 /ААН-4245, иргэн 2556/ аж ахуй нэгж, иргэн гаалийн мэдүүлгээр бүрдүүлэлт хийсэн лавлагаа авсан бол 2025 оны 6 дугаар сарын 10-ны байдлаар 23420 /ААН-5768, иргэн 17652/ аж ахуй нэгж, иргэн авсан нь өмнөх оны	2025.01.01-2025.06.10	100
----	---	-------------------------	---	---	---	-----------------------	-----

					мөн үетэй харьцуулахад 244%-аар өссөн үзүүлэлттэй байна. /Эх сурвалж: “Аствишн” ХХК/ 6. СЯ, ЭЗХЯаманд өгдөг өдөр бүрийн барааны экспорт, импортын мэдээлэл, инфографикийн “Статистик, дүн шинжилгээний програм”-ыг боловсруулан 2023.04.24-ны өдрөөс нэвтрүүлсэн бөгөөд цаг үеийн шаардлагаар 2025 онд дараах нэмэлт өөрчлөлт, хөгжүүлэлтийг хийж, програмыг өдөр тутамдаа ашиглаж байна. Үүнд: - Орлогын дүн шинжилгээний мэдээг ажлын хэсэгт тус тус цаг алдалгүй хүргүүлснээр шуурхай, үнэн зөвийг хангаж ажилласан үр дүн гарсан. Үүний үр дүнд: 1 мэдээний гаргах хугацааг хагас өдөр буюу 50 хувь хөнгөвчилсөн. Үүнд: 13.2-т заасан нийт импортын макро дүн, татварын дүнгийн харьцуулалт /2024, 2025 он, сараар, өссөн дүнгээр/ хийж үр дүнг тооцож гаргадаг 3.6-т заасан нийт гаалийн бүрдүүлэлтийн тооны харьцуулалтыг хийж үр дүнг тооцож, мэдээллийг сүүлийн 5 жилийн импортын бүрдүүлэлтийн тоо, үнийн дүн, цэвэр жинг гаалийн газар, хороогоор сар болон оны эхнээс өссөн дүнгээр 22-т заасан гаалийн мэдүүлгийн төлөвт цаг хугацааны хэмжилт ажлын хүрээнд оны эхнээс өмнөх 7 хоногийн даваа гарагийн хооронд гаальд мэдүүлсэн барааны мэдүүлгийн төлөвийг экспорт, импорт, гаалийн газар хороо, мэдүүлсэн сар, мэдүүлгийн тоо, үнийн дүн, татварын дүн гэсэн үзүүлэлтүүдээр нэгтгэн гаргадаг - Тухайн өдрөө “Гааль зөвшөөрөв” мэдүүлгийн тоог бүх горим, экспорт, импортоор гаргаж ХБГ-т		
4.	Гаалийн мэдүүлгийн цахим санд хяналт тавьж	Хэрэгжилт, хувиар	1. CAIS системд 3884 алдаа бүртгэгдсэн. 2. Нийт 1046 алдаа илрүүлсэн.	1. Гаалийн мэдүүлгийн алдаа илрүүлэлтийн хувь өссөн байна. 2. Гаалийн мэдүүлгийн бичлэгт хэрхэн хяналт	1. 2024 оны 6 дугаар сарын 10-ны байдлаар 496 мэдүүлгийг ГЕГ-аас буцаан засварлуулсан бол энэ оны 6 дугаар сарын 10-ны байдлаар манай хэлтсийн мэдүүлгийн сан хариуцсан ГУБ нар 840 алдаатай мэдүүлэг	2025.01.01-2025.06.10	100

	ажилласан байдал		3. Харьяа газар, хороодод 02-2.2/376 дугаар албан бичгээр чиглэл хүргүүлсэн.	тавьж ажилласан, алдаа илрүүлэлт, залруулга, алдааг дахин гаргуулахгүй байх чиглэлээр ажил зохион байгуулсан байна. 3. Харьяа гаалийн газар, хороодыг мэдүүлэгтэй ажиллах, мэдээлэл гаргахад удирдан чиглүүлж арга зүйгээр хангаж ажилласан байна.	буцаан засварлуулсан нь 344 мэдүүлгээр буюу 69.4 хувиар өссөн үзүүлэлттэй байна. 2. Алдааг дахин гаргуулахгүй байх чиглэлээр ажлуудыг хийж гүйцэтгэлээ. -2024 онд баталгаажсан төлвөөс буцааж засварласан мэдүүлгийн тайлан буюу "Мэдүүлгийн алдааны статистик тайлан"-г нэгтгэн боловсруулж, Захиргаа, дотоод ажлын систем (https://cerp.ecustoms.mn/)-д байршуулсан ба тус тайланг ГУБ, ГУАБ нарын алдааны дэлгэрэнгүй жагсаалт болон засвар оруулахаар илгээсэн хүсэлтийг татгалзсан мэдүүлгийн жагсаалтын хамт албан бичиг, дотоод зурвасаар Бүрдүүлэлтийн цахим төв болон 19 гаалийн газар хороодод хүргүүлэн ажилласан. -Замын-Үүд дэх гаалийн газраас автомашин, мотоциклын арлын дугаар, өнгө, даац, хэмжээ, үйлдвэрлэсэн он зэргийг дагалдах бичиг баримтын дагуу мэдүүлж, гаалийн бүрдүүлэлт хийгдсэн зарим мэдүүлгийг хавсаргасан дагалдах бичиг баримтад бичигдсэнээс өөрөөр засварлахаар тайлбар бичиж, удаа дараа хүсэлт ирүүлсээр байгаа тухай, цаашид гаалийн бүрдүүлэлт хийгдэж байгаа автомашин, мотоцикл гэх мэт тээврийн хэрэгсэл бүрийн мэдээллийн үнэн зөвийг ханган ажиллахыг анхааруулсан 02-2.2/1910 тоот албан бичгийг хүргүүлэн ажилласан. -Мэдүүлгийн цахим санг хугацаанд нь үнэн зөв, гүйцэд бүрдүүлэх болон "Барааны экспорт, импортын статистикийн мэдээлэл"-ийн 2024 оны жилийн эцсийн гүйцэтгэл гаргахтай холбогдуулан мэдүүлгийн сандаа хяналт тавьж, төлвийг хянан, шаардлагатай засвар өөрчлөлтийг хийн зохих төлөвт оруулах зэрэг үүрэг даалгаврыг дурдсан 02-2.2/91 тоот албан бичгийг гаалийн газар, хороодод, 01600/70 тоот дотоод зурвасыг БЦТ-д хүргүүлж, биелэлтийг хангуулан ажилласан. 3. Өмнөх оны 6 дугаар сарын 10-ны байдлаар 1303 мэдүүлгийг ГЕГ-т хүсэлт илгээн засварлаж байсан бол энэ оны мөн үед 1166 мэдүүлгийг хүсэлт илгээсэн нь 10.5 хувиар буурсан байна. Энэ нь манай хэлтсийн мэдүүлгийн сан хариуцсан ГУБ нар алдаа гаргуулахгүй байх		
--	---------------------	--	--	---	---	--	--

					үүднээс ихэвчлэн алддаг эсвэл алдаа гаргах магадлалтай бараа, хэмжих нэгж, улсын код нэр, горим хэлцлийн уялдаа, хил дээрх тээврийн хэрэгслийн төрөл гэх мэт статистик мэдээлэлд ач холбогдол бүхий үзүүлэлтүүдэд анхаарч, алдаа гаргахгүй ажиллахыг байнга сануулан гаалийн газар, хороодтой эргэх холбоотой ажилласны үр дүн юм.		
5.	Удирдлагыг мэдээллээр хангаж ажилласан байдал	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	1. Гаалийн удирдлагуудад гол нэрийн экспорт, импортын барааны инфографикаар ажлын өдөр 227 удаа, амралтын өдрүүдээр 109 удаа нийт 336 удаа хүргэсэн. 2. Гадаад худалдааны 2023 оны урьдчилсан болон жилийн эцсийн гүйцэтгэл, 2024 оны 1-ээс 11-р саруудын барааны статистик мэдээлэл, динамик статистик мэдээллийг боловсруулж гаалийн цахим хуудас www.gaali.mn/statistics-д байршуулсан. /13 удаа/. Экспорт, импортын гол нэрийн барааны мэдээг сарын эхний 15 хоногоор гарган цахимаар хүргүүлэн ажилласан. /11 удаа/ 3. Гаалийн захиргааны статистик мэдээллийг, дүн шинжилгээний хамт 2023.12-р, 2024 оны 1-11-р саруудын байдлаар 24 хавсралтаар эрхлэн гаргаж serp.ecustoms.mn-д байршуулсан. /13 удаа/ 4. ЭЗХЯаманд: Экспорт, импортын голлох бүтээгдэхүүний мэдээллийг өдөр бүр нийт 336 удаа, Хөдөө аж ахуйн экспортын голлох бүтээгдэхүүний мэдээллийг нийт 52 удаа. 5. ҮАБЗөвлөлд гол нэрийн экспорт, импортын барааны мэдээллийг БТКУС-ийн кодоор өдөр бүр гарган, цахимаар хүргүүлсэн. /нийт 240 удаа/	1. Гаалийн удирдлагуудыг өдөр бүр, 7 хоног болон тухай бүр гол нэрийг барааны экспорт, импортын мэдээллийг 2024 оны жилийн эцэс, 2025 оны 1-ээс 5 саруудын инфографикаар хүргэсэн байна. 2. Гадаад худалдааны барааны статистик 1-ээс 5 сарын мэдээлэл, динамик статистик мэдээлэл зэргийг гаалийн цахим хуудас www.gaali.mn-д нийтэлсэн байна. 3. Гаалийн захиргааны статистикийн мэдээллийг 1-ээс 5 сарыг боловсруулж, түгээсэн байна. 4. ҮАБЗ, УИХ, ЗГ-ын яамдууд болон бусад төрийн байгууллагад шаардлагатай мэдээллийг тухай бүр тогтоосон хугацаанд гаргаж хүргүүлсэн байна.	1. Гаалийн удирдлагуудад гол нэрийн экспорт, импортын барааны инфографикаар нийт 161 удаа хүргэсэн. 2. Гадаад худалдааны 2024 оны жилийн эцсийн гүйцэтгэл, 2025 оны 1-ээс 5-р саруудын барааны статистик мэдээлэл, динамик статистик мэдээллийг боловсруулж гаалийн цахим хуудас www.gaali.mn/statistics-д байршуулсан. /6 удаа/. Экспорт, импортын гол нэрийн барааны мэдээг сарын эхний 15 хоногоор гарган цахимаар хүргүүлэн ажилласан. /6 удаа/ 3. Гаалийн захиргааны статистик мэдээллийг, дүн шинжилгээний хамт 2024.12-р, 2025 оны 1-4-р саруудын байдлаар 24 хавсралтаар эрхлэн гаргаж serp.ecustoms.mn-д байршуулсан. /5 удаа/ 4. ЭЗХЯаманд: Экспорт, импортын голлох бүтээгдэхүүний мэдээллийг өдөр бүр нийт 336 удаа, Хөдөө аж ахуйн экспортын голлох бүтээгдэхүүний мэдээллийг нийт 22 удаа. 5. ҮАБЗөвлөлд гол нэрийн экспорт, импортын барааны мэдээллийг БТКУС-ийн кодоор өдөр бүр гарган, цахимаар хүргүүлсэн. /нийт 161 удаа/ 6. Монгол банкинд нийт 6 удаа гарган тус тус цахимаар хүргүүлэн ажилласан. 7. ГЕГ-ын дарга, дэд даргын үүрэг болгосны дагуу 13 удаагийн мэдээллийн бэлтгэж холбогдох байгууллагад хүргүүлсэн. 8. ГЕГ-ын бусад ЗББНДБ-уудад 13, газар, хороодод 2 удаагийн статистикийн мэдээллийг боловсруулж хүргүүлсэн. 9. ГЕГ-ын Орлогын төлөвлөгөөг биелүүлэх ажлын нийт 36 удаагийн мэдээллийг бэлтгэж хүргүүлсэн. 10. Сангийн яаманд нийт 16 удаагийн статистикийн мэдээллийг боловсруулж хүргүүлсэн.	2025.01.01-2025.06.10	100

			6. Монгол банкинд нийт 12 удаа гарган тус тус цахимаар хүргүүлэн ажилласан.				
6.	Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	1. "E-Mongolia", https://gaali.mn/: Нийт 39754 аж ахуй нэгж, иргэн авсан. 2. "1.1.5.Экспортыг дэмжих санхүүгийн шийдлүүдийг боловсруулж, экспортод гаргах бараа, бүтээгдэхүүний хэмжээг нэмэгдүүлнэ." ажлын хүрээнд өдөр бүр Эдийн засгийн хөгжлийн яам, Сангийн яаманд нийт 336 удаа. 3. ҮСХ, ЗТЯ, ТЕГ-уудтай хамтарч ажилласан.	Статистик, дүн шинжилгээний чиглэлээр бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангаж, тайлагнаж ажилласан байна.	Статистик, дүн шинжилгээний чиглэлээр бодлогын баримт бичигт тусгагдсан дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд: -МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН БАРИМТ БИЧИГТ ТУССАН ЗАСГИЙН ГАЗРЫН ТЭРГҮҮЛЭХ АЧ ХОЛБОГДОЛТОЙ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ-ийн Хоёр. Цахим шилжилт хэсэгт заасан "E-Mongolia" систем, Гаалийн цахим үйлчилгээний системээр https://gaali.mn/: 1. Гаалийн цахим үйлчилгээний систем www.gaali.mn -ны Статистик цонхонд Гадаад худалдааны барааны статистик мэдээллийг сар бүр байршуулж ажилласанаар 2024 оны 6 дугаар сарын 31-ний байдлаар 649 аж ахуй нэгж, иргэн экспорт, импортын статистик мэдээллийг авсан хандалт хийсэн бол 2025 оны 6 дугаар сарын 12-ны байдлаар 3,180 аж ахуй нэгж, иргэн, , CERP системд 147 авсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2531 хэрэглэгчээр 4 дахин буюу 412 хувиар өссөн үзүүлэлттэй байна. 2. Гаалийн цахим үйлчилгээний системээр https://gaali.mn/: 2. Гаалийн цахим үйлчилгээний системээр https://gaali.mn/: 2024 оны 6 дугаар сарын 10-ны байдлаар 6801 /ААН-4245, иргэн 2556/ аж ахуй нэгж, иргэн гаалийн мэдүүлгээр бүрдүүлэлт хийсэн лавлагаа авсан бол 2025 оны 6 дугаар сарын 10-ны байдлаар 23420 /ААН-5768, иргэн 17652/ аж ахуй нэгж, иргэн авсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 244%-аар өссөн үзүүлэлттэй байна. /Эх сурвалж: "Аствишн" XXX/	2025.01.01-2025.06.10	100

					- МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ-ний "1.1.5.Экспортыг дэмжих санхүүгийн шийдлүүдийг боловсруулж, экспортод гаргах бараа, бүтээгдэхүүний хэмжээг нэмэгдүүлнэ." ажлын хүрээнд өдөр бүр Сангийн яаманд ГЕГ-ын Захиргааны удирдлагын газраар дамжуулан экспортын барааны статистикийн мэдээллийг хүснэгт, инфографикийн дагуу 2025 оны 5-р сард хариуцан ажиллаж нийт 32 удаа гаргаж хүргүүлж ажилласан. - МОНГОЛ УЛСЫГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛ Цахим монгол (иргэн, төр, хувийн хэвшлийн нэгдсэн систем) Зорилт 5.3.Мэдээллийн аюулгүй байдлыг хангасан, үр дүнтэй цахим засаглалын бодлогын болон хууль, эрх зүйн орчныг бүрдүүлж, төлөвшүүлнэ: "5.3.3.төрийн байгууллага хоорондын болон төр, иргэний нийгэм, бизнесийн байгууллагуудын мэдээллийн солилцоо сайжирч, захиргааны зардал бууран, үйлчилгээний үр дүн сайжирна." ажлын хүрээнд хамтран ажиллах гэрээний дагуу Татварын ерөнхий газар, Үндэсний Статистикийн Төв хороо, Ашигт малтмал газрын тосны газарт өдөр тутмын барааны экспорт, импортын статистик мэдээлэл, Зам тээврийн яам уруу явуулж буй мэдээллийг тус тус дамжуулан цахим мэдээллийн санг хянаж ажилласан.		
7.	Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, эрх зүйн актын хэрэгжилт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	1. Статистикийн тухай хуулийн 5, 6-р зүйл, Гаалийн тухай хуулийн 14-р зүйлийн хэрэгжилт гадаад худалдаа 13, захиргааны статистик 12, нийт 25 удаа. 2. Гаалийн тухай хуулийн 13-р зүйлийн хэрэгжилт 100 хувь. 3. ҮАБЗөвлөлийн хэрэгжилт нийт 240 удаа 4. ЭЗХЯаманд нийт 388 удаа Хэрэгжилт: 80 хувь	1.Статистикийн тухай хуулийн 5, 6-р зүйл, Гаалийн тухай хуулийн 14-р зүйлийн хэрэгжилт 6 удаа 2. Гаалийн тухай хуулийн 13.2 дахь заалт, 14 дүгээр зүйлийн хэрэгжилтийг хангаж ажилласан байх. 3. Бусад хууль тогтоомж, тогтоол	1.Статистикийн тухай хуулийн 5, 6-р зүйлийн хэрэгжилт: Үндэсний статистикийн хороонд 2024 оны жилийн эцэс, 2025 оны эхний 1, 2, 3, 4, 5 саруудын мэдээний өгөгдлийн санг үүсгэж мэдээлэл дамжуулах бэлтгэл ажлыг хангасан, автомат горимоор илгээсэн. Түүнчлэн сар бүрийн 15-ны өдөр гадаад худалдааны барааны сарын урьдчилсан мэдээг нийт 6 удаа гаргаж цахимаар хүргүүлсэн. 2. Гаалийн тухай хуулийн 13-15-р зүйлийн хэрэгжилт:	2025.01.01-2025.06.10	100

				шийдвэр, эрх зүйн актын хэрэгжилтийг хангах.	-аалийн тухай хуулийн 13.2 дахь заалтын дагуу гаалийн мэдүүлгийн санг үндэслэн бүрдүүлсэн мэдээллийн санг шалгаж нийт 852 алдааг илрүүлж, гаалийн газар хороодоос мэдүүлэг засварлах 1431 хүсэлт ирснийг хянаж үзээд 116 хүсэлтийг зөвшөөрч, 265 хүсэлтийг татгалзаж ажилласан. ГЕГ-ийн алдаа илрүүлэлт өмнөх оны мөн үеэс 69 хувиар өссөн үр дүнтэй байна. -Гаалийн тухай хуулийн 14 дүгээр зүйлд зааснаар Гадаад худалдааны болон захиргааны статистикийн мэдээллийг батлагдсан аргачлалын дагуу 2024 оны жилийн эцэс, 2025 оны эхний 1, 2, 3, 4, 5 саруудын боловсруулж, дүн шинжилгээний хамт нийт 12 удаагийн мэдээллийг боловсруулж, түгээж ажилласан. 3. Гаалийн тухай хуулийн 15 дугаар зүйлд зааснаар Гадаад худалдааны барааны статистикийн мэдээллийг төрийн байгууллагад үнэ төлбөргүй нийт 109 албан бичгийн дагуу мэдээллийг гаргаж, хүргүүлж ажилласан. Өмнөх оны мөн үеэс 23-аар буюу 27 хувиар өссөн үзүүлэлттэй байна. 4. Бусад хууль тогтоомж, тогтоол шийдвэр, эрх зүйн актын хэрэгжилтийг хангаж ажилласан. 5. Нэгжийн хууль тогтоомжийн биелэлтийн тайланг ГЕГ-ын Хуулийн хэлтэст 2025.06.12-ны өдөр 01600/340 дугаар дотоод зурвасаар хүргүүлсэн.		
8.	Нэгжийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлсэн байдал	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	2024 оны үнэлгээ 4 оноо буюу 80 хувь.	1. Нэгжийн эрсдэлийг таньж тогтоосон, ангилж санд бүртгэсэн байна. 2. Эрсдэлд дүн шинжилгээ, үнэлгээ хийсэн, түүний үндсэнд бууруулах арга хэмжээ авсан байна.	СДШХ нь хэрэгжүүлэх үйл ажиллагааны хувьд эрсдлээс зайлсхийх бодлого баримтлан ажилладаг бөгөөд 2024 онд СДШХ-ийн эрсдэл үүсгэх хүчин зүйлсийг хүний хүчин зүйлс, дотоод үйл ажиллагаа дүрэм журамтай холбоотой хүчин зүйлс, мэдээллийн технологитой холбоотой хүчин зүйлс, гадаад хүчин зүйлс гэж дөрөв ангилан тодорхойлж, эрсдлийн түвшинг эрсдэлийн матрицийн аргаар тогтоож “маш бага”, “бага”, “дунд”, “өндөр”, “маш өндөр” гэж ангилсан. Өдөр тутмын үйл ажиллагаанд хүний хүчин зүйлс, Мэдээллийн технологитой холбоотой хүчин зүйлстэй холбоотой эрсдлийг хүлээн зөвшөөрөгдөх хэмжээнд байсаар байна гэж үзэж байна.	2025.01.01- 2025.06.10	100

					1.Хүний хүчин зүйлс: Орон тоо дутуу - Батлагдсан орон тооноос тус хэлтсийн үйл ажиллагааг удирдан зохицуулах ГУАБ-ын орон тоо дутуу тул яаралтай томилуулах; Нарийн мэргэжлийн хүний нөөцийг олоход хүндрэл- Нарийн мэргэжлийн статистикч ГУБ дутагдалтай. Тухайн газрын статистикч ГУБ өндөр насны тэтгэвэрт гарах, сэлгэн ажиллах тохиолдолд тухайн ажлыг гүйцэтгэх нарийн мэргэжлийн боловсон хүчин байхгүй. Энэ чиглэлээр статистикч мэргэжлийн ГУБ яаралтай томилох, сурган бэлтгэх шаардлагатай хэвээр байна. 2.Мэдээллийн технологитой холбоотой хүчин зүйлс: Серверийн хэвийн ажиллагаа, аюулгүй байдал бүрэн хангагдаагүй - Мэдээллийн технологийн чиглэлийн хүний нөөц болон мэдлэг ур чадвар дутмаг учраас маш өндөр эрсдэлтэй гэж үзэж байна. Иймд дүгнээд хэлбэл хүлээн хэвшөөрөгдсөн эрсдлийг таньж тогтоосноор тус хэлтэсээс дараах ажлыг хийж гүйцэтгэсэн. 1. Нэгжийн эрсдлийн нэг болох боловсон хүчний асуудал ойрын 2 жилд хомсдолд орох эрсдэлтэй хэдийн ч хүний хүчин зүйлээс үл хамааран Статистик мэдээллийг програмаар гаргах, Таблью болон "Статистик дүн шинжилгээний програм"-д нэмэлт модулийг боловсруулж, нэвтрүүлээд ашиглаж байна. 2. Мөн гаалийн мэдээллийн их өгөгдөлтэй ажиллах технологи ажиллагааг сайжруулах ажлын хүрээнд Мэдээллийн технологийн газартай гаалийн дата агуулахын өгөгдлийн санг, КАИС-ын бүрдүүлэлтийн өгөгдлийн сантай Realtime холбох ажлыг хийж гүйцэтгэж нэвтрүүлээд байна. Цаашид КАИС системийн өгөгдлийн сан уруу нэвтрэхгүйгээр "Өгөгдлийн агуулах - DW" өгөгдлийн сантай ажиллах, хүнээс хамаарахгүй гадаад худалдааны статистикийн мэдээллийг гаргахад програмын сайжруулалтыг хийхээр ажиллаж байна Шийдвэрлэх асуудал: ГЕГ-ын ХНХ-т 2 саналыг хүргүүлсэн.		
--	--	--	--	--	---	--	--

9.	Нэгжид ирүүлсэн үүрэг даалгаврын биелэлтийг хангах	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	2024 онд нэгжийн үүрэг даалгаврын биелэлт 96 хувийн үнэлгээгээр дүгнэгдсэн.	1. Өгөгдсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь бүрэн биелүүлж ажилласан байна. 2. Бусдад хүргүүлсэн үүрэг даалгаврын биелэлтийг хугацаанд нь дүгнэж, ЗДАС программд үнэлсэн байна.	- УИХ, Ерөнхийлөгчийн тамгын газар /Хүнсний хувьсгал/, Сангийн яам, Эдийн засгийн хөгжлийн яам, Үндэсний статистикийн хороо, Монгол банк, Үндэсний аюулгүй байдлын газар, ХХААЯ, ЭМЯамнаас ирүүлсэн хугацаатай үүрэг даалгавруудыг хэрэгжүүлж, судалгаа мэдээллийг хугацаанд нь хүргүүлж 100 хувийн биелэлттэй ажилласан. - 2025 оны эхний хагас жилийн байдлаар /2025.01.01-2025.06.10/ 10 үүрэг даалгавар 11 зөвлөмж, ёс зүйн дэд хороо 1, мэргэжлийн зөвлөлийн хуралдааны 1, онлайн хурлын 1, цаг үеийн шинжтэй 2 нийт 26 үүрэг даалгаврууд тус хэлтэст Гаалийн захиргаа, дотоод ажлын систем /ЗДАС/-т ирсэн байна. Нийт өгөгдсөн 26 үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь биелэлтийг ханган ажилласан ба 3 үүрэг даалгавар илгээсэн төлөвт, 2 үүрэг даалгавар үнэлэгдэхгүй ба 1 үүрэг даалгавар 80%, 1 зөвлөмж 80%, 19 үүрэг даалгавар 90%-иас дээш үнэлгээнтэй үнэлэгдсэн байна. 2025 оны эхний хагас жилийн байдлаар 21 үүрэг даалгаврын дундаж үнэлгээ 96%-иар үнэлэгдсэн байна.	2025.01.01-2025.06.10	100
10.	Ажлын цаг ашиглалт	Хувиар	Нэгжийн цаг ашиглалт 2024 онд 98 хувьтай.	Ажлын цаг ашиглалт сайжирсан байн	Ажлын цаг ашиглалтын байдлыг 2025 оны эхний хагас жилийн байдлаар /2025.01.01-2025.06.10/ гаргавал: Гаалийн ерөнхий газрын Статистик, дүн шинжилгээний хэлтэс нь хэлтсийн дарга-1, ГУБ-7 нийт 8 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байгаа бөгөөд 912 хүн өдөр буюу 7296 цаг ажиллахаас 10 хүн өдөр буюу 80 цаг өвчтэй, 10 хүн өдөр буюу 80 цаг чөлөөтэй, 77 хүн өдөр буюу 616 цаг ээлжийн амралттай, 815 хүн өдөр буюу 6520 цаг ажилласан байна.	2025.01.01-2025.06.10	100
11.	Өгөгдлийн дүн шинжилгээ, их өгөгдөлд суурилсан дэвшилтэт технологийг ашиглах	Хэрэгжилтийн эерэг үзүүлэлт	Tableau программыг ашиглан дараах дашбоардуудыг боловсруулах ажилд санал өгч, тест сервер дээр туршилт хийсэн, жинхэнэ серверт суулгадаагүй, туршилт хийгдээгүй, бүрэн ажиллагаанд ороогүй. - Экспортын статистик мэдээлэл	Tableau програмыг ашиглан дараах дашбоардуудыг боловсруулах ажилд санал өгч, тест, туршилтыг дахин хийж, бүрэн ажиллагаанд оруулах ажлыг зохион байгуулах.	Өгөгдлийн дүн шинжилгээг сайжруулах, их өгөгдөлд суурилсан дэвшилтэд технологийн ашиглалтыг сайжруулах ажлын хүрээнд дараах програмуудыг хөгжүүлж, нэвтрүүлсэн. Үүнд: 1. Нэгжийн албан хаагчид хамтран гаалийн цахим үйлчилгээний систем www.gaali.mn/statistic цэсэнд байршиж буй хайлтын системийг сайжруулах бодлогын даалгавар боловсруулж ГЕГ-ын 2025.05.09-ны өдрийн 02-2.2/1949 тоот албан бичгээр	2025.01.01-2025.06.10	100

			- Импортын статистик мэдээлэл		“Аствишн” ХХК-д системд нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг явуулсны үр дүнд ухаалаг хайлтын систем сайжирч ашиглахад хялбар болсон. 2. Tableau системийн “Customs 360 Dashboard”-ийн “ГЕГ-Экспортын статистик мэдээлэл”, “ГЕГ-Импортын статистик мэдээлэл”-ийн дашбоард буюу мэдээллийн самбарыг сайжруулах саналыг Мэдээллийн технологийн газарт хүргүүлж, хамтран ажилласны үр дүнд тус дашбоард ашиглах боломжийг бүрдүүлсэн. Гаалийн орлогын төлөвлөгөөг биелүүлэх ажлын “Мэдээлэл, судалгаа, дүн шинжилгээ баг”-т ГЕГ-ын даргын тушаалаар ажиллах хугацаандаа “Орлогын дүн шинжилгээ”-ний дашбоардыг санаачилж МТГ-т хамтран боловсруулж, ашиглаж байна. 3. ГЕГ-ын даргын 2025.04.07-ны өдөр баталсан “Татварын орлогын төлөвлөгөөний гүйцэтгэлийг хангах ажлын төлөвлөгөө”-нд тусгасан дараах ажлуудыг хийж гүйцэтгэхэд шаардлагатай тайлангуудыг тус програмд 5 нэмэлтээр хөгжүүлэлт хийж нэвтрүүлсэн.		
12.	Тоон гарын үсэг ашиглан "Нээлттэй өгөгдлийн нэгдсэн портал opendata.gov.mn"-д гадаад худалдааны статистикийн мэдээлэл байршуулах	Тоон гарын үсэг ашиглаж оруулсан мэдээллийн тоо	Тоон гарын үсэг ашиглан "Нээлттэй өгөгдлийн нэгдсэн портал - opendata.gov.mn"-д гадаад худалдааны статистикийн мэдээлэл байршуулах	Нэгжийн удирдлага албан бичиг хэрэг хөтлөлтийн идок системд тоон гарын үсгийг ашиглаж байна. Бусад ГУБ нарт цахим гарын үсэг олгогдоогүй байна. Тоон гарын үсэг ашиглаж оруулсан мэдээллийн тоо байхгүй.	Тоон гарыг үсэг ашиглаж СДШХ-ийн дарга 2025 оны эхний хагас жилийн байдлаар нийт 432 албан бичиг, дотоод албан бичгийг холбогдох байгууллага, ГЕГ-ын ЗББНДБ болон гаалийн газар, хороодод цахимаар хүргүүлж ажилласан. Цахим хөгжил, инноваци, харилцааны холбооны яамны Цахим засаглалын хэлтсийн "Нээлттэй мэдээлэл, өгөгдөл хариуцсан мэргэжилтэн" М.Номинтой /Утасны дугаар: 99038627/ холбогдож дараах 3 төрлийн мэдээллийг www.opendata.gov.mn нээлттэй мэдээлэл байршуулах платформд өдөр бүр оруулах горимыг сар бүр оруулах горим болгож өөрчлөхөөр тохиролцож ГЕГ-ын зүгээс албан бичгээр хүсэлт өгөхөөр болсон. Мөн Олон нийттэй харилцах албанд 2025.02.12-ны өдөр дотоод зурвасаар тус платформд мэдээлэл байршуулах ажлын талаар мэдээлэл явуулсан. Цахим хөгжил, инноваци, харилцаа холбооны яамны Цахим засаглалын хэлтсийн	2025.01.01-2025.06.10	100

					хөгжүүлэгч н.Баттөмөртэй /Утас: 88005552/ холбогдож СДШХ-ийн даргын тоон гарын үсгийг www.opendata.gov.mn сайттай холбож нийт 8 удаагийн гадаад худалдааны барааны статистикийн 2024 оны жилийн эцэс, 2025 оны 1-5 саруудын мэдээллийг байршуулсан.		
13.	Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	Өмнө онд хийгдээгүй ажил	Нэвтрүүлсэн цахим үйлчилгээний чанар хүртээмжийн талаар иргэд, олон нийтээс судалгаа, санал асуулга авсан байна.	Gaali.mn, E-Mongolia -г НЭВТРҮҮЛСЭН ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР ХҮРТЭЭМЖИЙН ТАЛААР 2024 оны 6-р сарын 7-ны өдрөөс 2024 оны 6-р сарын 14-ны хооронд Монголын гааль пейж хуудсаар дамжуулан гадаад худалдаанд оролцогч иргэд аж ахуй нэгжээс Google form ашиглан авсан. Судалгаанд 123 хүн 10 асуултын хүрээнд хамрагдсан. Судалгааны тайланг хавсаргав	2025.01.01-2025.06.10	100
14.	Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	2024 оны гүйцэтгэл 100 хувь	1. Үндсэн шалгуурт тусгагдаагүй ЗББНДБ болон харьяа гаалийн газар, хороодын уялдаа холбоог хангаж ажилласан байна. 2. Цаг үеийн шинжтэй бусад арга хэмжээ, шаардлагатай програмын шинэчлэлт, хөгжүүлэлт, ажлын хэсгийн үйл ажиллагаанд оролцсон байна.	1. “Татварын орлогын төлөвлөгөөний гүйцэтгэлийг хангах ажлын төлөвлөгөө”-нд тусгасан дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд: -13.2-т заасан нийт импортын макро дүн, татварын дүнгийн харьцуулалт /2024, 2025 он, сараар, өссөн дүнгээр/ хийж үр дүнг тооцож, мэдээллийг ТОГ-т 7 хоног бүр хүргүүлсэн. /нийт 8 удаа/ - 13.5-т заасан Замын-Үүд болон Алтанбулаг боомтын ачаатай тээврийн хэрэгслийн тоон мэдээлэлтэй холбоотой дүн шинжилгээг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулсан байдлаар өдөр бүрээр гаргаж үр дүнг тооцож, мэдээллийг ТОГ-т хүргүүлсэн. -13.6-т заасан нийт гаалийн бүрдүүлэлтийн тооны харьцуулалтыг хийж үр дүнг тооцож, мэдээллийг сүүлийн 5 жилийн импортын бүрдүүлэлтийн тоо, үнийн дүн, цэвэр жинг гаалийн газар, хороогоор зөвхөн тухайн 4, 5 сар болон оны эхнээс өссөн дүнгээр гэж гарган ТОГ-т хүргүүлсэн. -14-т заасан улсын хилээр импортолсон олон нэр төрлөөр мэдүүлж байгаа ачилтын үнийн дүн, тоо хэмжээнд судалгааг хийж үр дүнг тооцож, мэдээллийг ТОГ-т 7 хоног бүр хүргүүлсэн. -22-т заасан гаалийн мэдүүлгийн төлөвт цаг хугацааны хэмжилт ажлын хүрээнд оны эхнээс өмнөх 7 хоногийн даваа гарагийн хооронд гаальд мэдүүлсэн барааны	2025.01.01-2025.06.10	100

					мэдүүлгийн төлөвийг экспорт, импорт, гаалийн газар хороо, мэдүүлсэн сар, мэдүүлгийн тоо, үнийн дүн, татварын дүн гэсэн үзүүлэлтүүдээр нэгтгэн гаргаж, Дэд дарга Г.Энхтайван, БЦТ-ийн ГУАБ Алтанчимэг нарт нийт 7 удаа хүргүүлж ажилласан. -38-т заасан ГЕГ-ын ЗББНДБ-ын албан хаагчдад өгөгдлийн дүн шинжилгээ буюу дата аналитикийн сургалтыг 6-р сард зохион байгуулсан. 2. XVII дугаар жарны "Элдэв эрдэнэт" хэмжээх модон могой ажилийн сар шинийн баярын өдрүүдэд 2025.03.04-ны өдөр хариуцлагтай жижүүрээр ажилласан.		
15.	Зураасан код, түүнтэй адилгах кодыг гаалийн мэдүүлэгт нөхөн бичихтэй холбоотой сургалт, сурталчилгаа зохион байгуулах	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	Гаалийн мэдүүлгийн II хэсэгт бар код нөхөн бичих талбар нэмж оруулсан.	Зураасан код, түүнтэй адилгах кодыг гаалийн мэдүүлэгт нөхөн бичихтэй холбоотой сургалтыг Дэлхийн Стандарт Нэг Монгол Нийгэмлэг ТББ-тай хамтран зохион байгуулахад оролцсон байна.	Гаалийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2-т Энэ хуулийн 13.1-д заасан мэдээллийг Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан системийн ангилал болон Татварын ерөнхий хуулийн 33.4-т заасан журмын дагуу олгосон зураасан болон түүнтэй адилтгах код, нэр төрлөөр гаргахаар зохицуулсан. Энэ зохицуулалтын хэрэгжилтийг хангах зорилгоор Барааны зураасан код болон түүнтэй адилтгах кодыг олон улсын стандартын дагуу давхардалгүй үүсгэхтэй холбоотой асуудлаар 2025.01.31-ний өдрийн 14:00 цагт МТГ-ын ГУАБ Н.Мөнхзул, СДШХ-ийн ГУБ Д.Нямдагва нарын хамт Д:Ариунцэцэг, М.Батбилэг нар Дэлхийн Стандарт Нэг Монгол Нийгэмлэг ТББ-ийн захирал Ш.Цэвэлсайхантай уулзалт зохион байгуулж санал солилцсон. Дээрх уулзалтын үр дүнд Дэлхийн Стандарт Нэг Монгол Нийгэмлэг ТББ-ын захирал Ш.Цэвэлсайхантай хамтран барааны зураасан код болон түүнтэй адилтгах кодыг олон улсын стандартын дагуу давхардалгүй үүсгэхтэй холбоотой асуудлаар: - ГЕГ-ын БЦТ-ийн 36 албан хаагчид 2025 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн 08:00 цагт; - УБГГ-ын 130 албан хаагчид 2025 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн 08:00 цагт; - ЧХОУНБГГ-ын 101 албан хаагчид 2025.05.20-ны өдрийн 08:00 цагт; - УХШИГГ-ын 48 албан хаагчид 2025.06.04-ний өдрийн 08:00 цагт тус тус зохион байгуулж, гаалийн байгууллагын 315 албан хаагчид танхимын сургалт зохион байгуулсан.		

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин	Эхэлсэн дууссан хугацаа	Биелэлт ийн хувь
	1	2	3	4	5	6	7
1.	Өгөгдлийн дүн, шинжилгээний чиглэлээр гадаад, дотоод сургалтанд хамрагдаж мэдлэг, ур чадвараа дээшлүүлсэн байна.	Албан тушаалын чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдлэг, чадвартай болсон байх	Өгөгдлийн дүн шинжилгээний дунд буюу Excel, SQL хэлний мэдлэгтэй	Өгөгдлийн дүн, шинжилгээний ахисан түвшний мэдлэгтэй болсон байна	ДГБ-аас зохион байгуулж Дата аналитик буюу өгөгдлийн дүн шинжилгээний Тайланд улсын Бангкок хотноо болсон сургалтанд 2025.03.24-03.28-ны хооронд хамрагдаж мэдлэг, чадвараа дээшлүүлсэн. Python хэлний анхан шатны мэдлэгтэй болсон.	2025.03.24-2025.03.28	100%
2.	Өгөгдлийн дүн, шинжилгээний чиглэлээр гадаад, дотоод сургалтанд хамрагдаж мэдлэг, ур чадвараа дээшлүүлсэн байна.	Албан тушаалын чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдлэг, чадвартай болсон байх	Өгөгдлийн дүн шинжилгээний дунд буюу Excel, SQL хэлний мэдлэгтэй	Өгөгдлийн дүн, шинжилгээний ахисан түвшний мэдлэгтэй болсон байна	ГЕГ-ын даргын 2025 оны А/152 дугаар тушаалаар батлагдсан "Судалгаа, дүн шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах" багийн бүрэлдэхүүнд орж ажиллаж, "Power BI" програмыг ашиглаж, мэдээллийн дүн шинжилгээ хийх сургалтанд 2025.06.10-ны өдөр хамрагдаж мэдлэг, чадвараа дээшлүүлсэн. Мөн бие даан гүнзгийрүүлэн судалсан.	2025.06.01-2025.06.10	100%

ТАЙЛАН ГАРГАСАН:

СТАТИСТИК, ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
(Албан тушаал)


..... /Б.Баясгалан/
(Нэр, гарын үсэг)

.....
(Огноо)

СТАТИСТИК, ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Б.БАЯСГАЛАНГИЙН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН АЖЛЫН
ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Байгууллагын нэр: Гаалийн ерөнхий газар
Нэгжийн нэр: Статистик, дүн шинжилгээний хэлтэс

1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ	Гүйцэтгэлийн түвшин	Нийт оноо (70 оноо)
1	2	3	4
1	Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт		61,8

2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний биелэлтийг хувь	Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор)
1.	Өгөгдлийн дүн, шинжилгээний чиглэлээр гадаад, дотоод сургалтанд хамрагдаж мэдлэг, ур чадвараа дээшлүүлсэн байна.		14,5
Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний дундаж оноо:			14,5

3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ

Д/д	Үзүүлэлт	Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор)
1.	Хандлага, ёс зүй	14
2.	Удирдан зохион байгуулах	13
3.	Асуудал шийдвэрлэх	13
4.	Манлайлах	13
5.	Багаар ажиллах	13
6.	Харилцаа	13
Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан)		13
7.	Мэргэжлийн ур чадвар 1.	
Хандлага, ёс зүй, ур чадварын дундаж оноо		13

4. Гүйцэтгэлийн үнэлгээ

Д/д	Үнэлгээний үзүүлэлт	Үзүүлэлт тус бүрийн оноо
1.	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт	61,8
2.	Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт	14,5
3.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ	13
4.	Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт	—
Нийт оноо= (Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо+Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо+Хандлага, ёс зүй, ур чадварын оноо) – Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо		89,5

Үнэлгээ өгсөн:

Гаалийн ерөнхий газрын дарга

Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:

Статистик, дүн шинжилгээний хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч



Төсвийн шууд захирагч:

(Р.Отгонжаргал)

2025.06.25 (огноо)

Нэгжийн дарга:

(Б.Баясгалан)

2025.06.10 (огноо)